



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 4/695

Арвайхээр

Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1-ийн “а”, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.1, 7.6.2, 7.6.3, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 6, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Татварын ерөнхий хуулийн 29, 47, Зөрчлийн тухай хуулийн 14.6.5, 14.6.12, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.2 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвлийн улирал эхэлж иргэд, малчид хүнс, мод түлээгээ нөөцлөх мал, мах, модны нийлүүлэлтийг дагаад хулгайлах, хууль бусаар ан агнах, хууль бусаар мод бэлтгэх, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, мал амьтны гоц халдварт өвчин (шүлхий, цэцэг, мялзан гэх мэт)-ний голомтот бүхий газраас тээвэрлэгдэн ирж байгаа малын хөдөлгөөнд хяналт тавих, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татварын хэрэгжилтийг хангах, иргэдийн аюулгүй байдлыг хангах, хот хоорондын болон орон нутгийн замд техникийн бүрэн бүтэн байдлыг хангаагүй, зөвшөөрөлгүй тээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэх явдлыг зогсоох, эдгээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт хийх зорилгоор “Хяналт Шалгалт-2018” нэгдсэн арга хэмжээг 2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 30 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. “Хяналт Шалгалт-2018” нэгдсэн арга хэмжээний хүрээнд постонд ажиллах алба хаагч нарт шаардлагатай орон байр, түлээ нүүрс, шатах тослох материалаар дэмжлэг үзүүлэн ажиллахыг сумдын Засаг дарга, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга нарт даалгасугай.

3. Нэгдсэн арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. “Хяналт Шалгалт-2018” нэгдсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй зохион явуулж, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллах, дүнг танилцуулахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа О.Ганбат), Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Д.Эрдэнэбат), Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга (С.Дуламсүрэн), Татварын хэлтсийн дарга (Н.Эрдэнэсүвд), Мал эмнэлгийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Нямдаваа), Авто тээврийн төвийн дарга (З.Балданям), сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

011101507

D:My Doc. Zahiramj. Zasag darga

5. Нэгдсэн арга хэмжээнд зарцуулагдах 15.835.080 (арван таван сая найман зуун гучин таван мянга ная) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (А.Отгонцэцэг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

Аймгийн Засаг даргын 2018 оны 11...
дугаар сарын 16...-ны өдрийн 11695 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

**“ХЯНАЛТ ШАЛГАЛТ-2018” НЭГДСЭН АРГА
ХЭМЖЭЭ ЯВУУЛАХ УДИРДАМЖ**

Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах үндэслэл:

Аюулгүй иргэн-Амар тайван Өвөрхангай хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Аймгийн хэмжээнд гарч байгаа мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, Эрүүгийн хууль, Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авто замын тухай хууль, Байгаль хамгаалах тухай хууль, Татварын ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулагдах хугацаа:

2018 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдөр хүртэл

Нэгдсэн арга хэмжээний хамрах хүрээ, хүн хүч:

Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Татварын хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газар, Хүнс хөдөө аж ахуйн мал эмнэлгийн алба, Авто тээврийн үндэсний төвийн Өвөрхангай аймаг дахь салбар, сумдын Засаг даргын тамгын газрын алба хаагч нар хамрагдана.

Удирдлага зохион байгуулалт:

Нэгдсэн арга хэмжээг Цагдаагийн газар удирдан зохион байгуулна. Арга хэмжээний хүрээнд түр хугацаагаар байгуулагдсан хяналтын постуудыг байгууллагын дарга нар хариуцан үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллана.

Байгууллагаас ажиллах алба хаагч нарын хуваарийг 7 хоногоор гаргаж цагдаагийн газарт ирүүлнэ.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд хариуцсан постын хийж гүйцэтгэж байгаа ажил, ажиллах нөхцөл байдлыг үнэлж дүгнэж, нөхцөл байдалдаа уялдуулан зөрчил, гэмт хэрэг, байгалийн хүндрэл бэрхшээлээс хамаарч хяналтын постыг нүүлгэн шилжүүлэх ажлыг цагдаагийн газрын даргатай зөвшилцөж өөр газарт шилжүүлэн байршуулж болно.

Арга хэмжээнд сумдын Засаг дарга нар, сумдын алба хаагчийг удирдлага зохион байгуулалт болон шаардлагатай пост байгуулах зөврийн чингэлэг, гэр, тээврийн хэрэгсэл, хүнс, шатах тослох материалаар хангахад туслалцаа үзүүлнэ.

Нэгдсэн арга хэмжээг үнэлж дүгнэх:

Хяналтын пост өдөр тутам мэдээний хүснэгтээр Цагдаагийн газрын шуурхай удирдлагын жижүүрийн хоногийн мэдээнд ирүүлж ажиллана.

Пост удирдан ажиллаж байгаа байгууллагын дарга 7 хоног тутам цагдаагийн газарт танилцуулга ирүүлж, түүнийг 14 хоног бүр нэгтгэн аймгийн Засаг даргад хийж гүйцэтгэсэн ажлын танилцуулгыг хүргүүлнэ.

Арга хэмжээний хугацаанд байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд идэвх санаачилагатай ажилласан байгууллага, удирдлага, алба хаагчийг хамтран оролцож байгаа байгууллага, Засаг даргын шагналаар шагнаж урамшуулна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

